

2018 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг. Удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн талаар

Хүний нөөцийн чиглэлээр 16, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 2, нийт 18 тушаал гаргаж, алба хаагч, ажилчдаас 12 өргөдөл хүлээж авснаас ажлаас чөлөлөгдөхийг хүссэн 2, шилжихийг хүссэн 1, захиргааны чөлөө хүссэн 7, бусад 8 өргөдлийг хүлээж авсан байна.

14 алба хаагч, ажилтныг томилж, 1 алба хаагч, ажилтныг чөлөөлж, 1 алба хаагчийг шилжүүлж, 1 алба хаагчид хүүхэд асрах чөлөө олгож, 6 алба хаагчид цагдаагийн цол олгосон байна.

Чуулгын даргаас 7 хоног тутам хэсгийн дарга нар болон офицеруудад нэг бүрчлэн үүрэг, чиглэл өгч биелэлтийг бичгээр авч хэвшсэн ба гуравдугаар улирлын байдлаар нэгтгэн гаргасан.

Нийт 5 удаа, давхардсан тоогоор 21 алба хаагчид нийт 104 үүрэг, даалгавар өгч биелэлтийг тооцож ажилласан байна.

Ажлын үр дүнгээр 3 алба хаагчийн сарын үндсэн цалинг 2 сар 20, 1 алба хаагчийг 1 сар 30, 16 алба хаагч, ажилтныг 1 сар 20, 13 алба хаагчийг 1 сар 15, 28 алба хаагчийг 1 сар 10 хувиар тус тус урамшуулсан.

Ажлын үр дүнгээр хангалтгүй дүгнэгдсэн 1 алба хаагчийн 2 сар 20, 19 алба хаагчийн 1 сар 20, 4 алба хаагчийг 1 сар 10 хувиар тус тус цалинг урамшуулж, 1 алба хаагчийг 1 сар 10 хувиар цалинг бууруулж тооцсон.

Чуулгын даргын зөвлөлийн хурлыг 4 удаа хийж хүний нөөцтэй холбоотой 11, үйл ажиллагаатай холбоотой 0, нийт 11 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

Тулгар төрийн 2227, Их Монгол Улсын 812, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын болон Цагдаагийн байгууллагын 97 жилийн ойг тохиолдуулан Засгийн газрын шагнал “Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан” цолоор Бүжигчин, цагдаагийн дэд ахлагч Ё.Дамчаабадгар, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны Б/504 дүгээр тушаалаар Төлөвлөлт, зохион байгуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч С.Дуламсүрэн “Цагдаагийн гавьяа” тэмдгээр, тонмейстр Р.Энхболд “Цагдаагийн төлөө тэмдгээр, мөн даргын 2018 оны Б/485 дугаар тушаалаар “Цагдаагийн дэслэгч” цолоор Бүжгийн багш, бүжиг дэглээч У.Оюунномин, хцгацааны өмнө “Цагдаагийн ахлах дэслэгч” цолоор Б.Нямцэцэг, Хүний нөөцийн хэлтсийн 56/4143 тоот албан бичиг, зөвшөөрлийг үндэслэн 2018 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс Тус чуулгын бүжигчин, цагдаагийн дэд ахлагч Мухархөхийн Энхзолбоо, Энхбаатарын Жаргалмаа нар хугацааны өмнө “цагдаагийн ахлагч” цолоор тус тус шагнагдсан.

Тус чуулгад 2018 оны гуравдугаар улирлын байдлаар 1 иргэн, 2 алба хаагчыг судалж чуулгын даргын тушаалаар томилсон.

Алба хаагчдын 2018 оны ээлжийн амралтын хуваарийн дагуу 8 дугаар сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 10-ны хугацаанд олгосон байна.

Тус чуулгын жижүүрийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Ганхуягийн Очироо нь Хууль сахиулахын их сургуулийн 2018-2019 оны хичээлийн жилийн бакалаврын эцнээ 3 жилийн сургалтад элсэн суралцах болсон боловч биеийн эрүүл мэндийн улмаас 2018-2019 оны хичээлийн жилд суралцах боломжгүй болсон тул жилийн чөлөө олгуулахаар ХСИС-д холбогдох материалыг хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын төв архив Байгууллагын архив нь Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын үндсэн заавар”-ын шаардлагыг хангаж байгаа тул Төв архивын даргын 2018 оны А/31 тушаалаар байгууллагын архивын 045 дугаартай гэрчилгээ олгогдов.

Хоёр. Сахилга хариуцлагыг төлөвшүүлэх, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлын арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар

Сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр: Чуулгын даргаас өгсөн хугацаат үүргийг офицер, ажилтнуудаас хэрхэн биелүүлж байгааг дүгнэх, офицер алба хаагчдын ажлын хариуцлага, манлайллыг дээшлүүлэх зорилгоор “Сүлд” чуулгын офицер, ажилтнуудад өгсөн хугацаат үүргийн биелэлтийг дүгнэх мандатын зааврыг боловсруулан 2018 оны А/06 тоот тушаалаар баталгаажуулан мөрдөн ажиллаж байна.

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн тангараг анх болон давтан өргөх ёслол /код-905/ журам”-ын 905.1-д зааснаар Сүлд чуулгад 2017-2018 онд шинээр томилогдсон 16 алба хаагч Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 1,3 дугаар хэлтэс, Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэс, Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл хяналтын төв зэрэг цагдаагийн байгууллагын 64 алба хаагчийн хамт “Цагдаа цогцолбор”-т тангараг өргөх ёслолыг зохион байгууллаа.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/143 дугаар тушаалаар “Дүрэмт хувцас хэрэглэх журам” шинэчлэн батлагдсантай холбогдуулан журмыг алба хаагчдад танилцуулан 2018 оны А/141 дүгээр тушаалаар “Шагнал, урамшуулал олгох /код-925/ журам”-ын хавсралтад өөрчлөлт орсонтой холбогдуулан батлагдсан загварын дагуу тэмдэг, медалийн туузыг хэрэглэх, шинэчлэгдсэн журмуудыг алба хаагч нарт судлуулах ажлыг зохион байгуулав.

Нэмэлт өөрчлөлт орсон ЦБҮАЖ код 100, 101, 123,136, Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газрын зарим тасгийн дарга, алба хаагчдын ёс зүйтэй холбоотой үйлдэлд албаны шалгалт хийж ЦЕГ-ын даргын зөвлөлийн 2018 оны 11 дүгээр хуралдаанаар хэлэлцэж, гаргасан шийдвэр болон түүнтэй холбогдуулан ирүүлсэн 8 төрлийн үүргийг алба хаагч нарт танилцуулав.

Сургалтын чиглэлээр: 2018 оны гуравдугаар улиралд сургалтад хамрагдвал зохих 66 алба хаагч, ажилтнуудаас 3 удаагийн сургалтад давхардсан тоогоор 172 алба хаагч, ажилтнууд хамрагдаж, сургагч багш тус чуулгын соён гэгээрүүлэх, албаны сургалт хариуцсан мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Б.Нямцэцэг “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” сэдвээр 2 удаагийн 4 цагийн хичээлийг Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу орж, алба хаагчдаас мэргэжлийн болон бие бялдрын шалгалтыг тус бүр 1 удаа, эрх зүйн шалгалтыг 2 удаа авсан.

Эрх зүйн шалгалтаар А-2, В-7, С-8, D-6, F-8, бие бялдарын шалгалтаар А-11, В-4 үнэлгээтэйгээр тус тус дүгнэгдсэн.

Чуулгын даргын 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдөр баталсан удирдамжийн дагуу чуулгын уран бүтээлчдээс гүйцэтгэлийн ур чадвар, онолын мэдлэгийг дээшлүүлэх, мэргэжлийн түвшинд үнэлэмж тогтоох, чуулгын стандарт шаардлагын хэрэгцээг тодорхойлох зорилгоор мэргэжлийн ур чадварын түвшинг тогтоох шалгалтыг 2018 оны 06 дугаар сарын 21, 22, 27-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Дуу ангиас Монгол улсын консерваторийн онолын багш Ч.Энхбат, чуулгын концертмейстр, МУСТА Т.Энхтуул, бүжиг ангиас СУИС-ийн Бүжгийн тэнхмийн эрхлэгч, МУГЖ Д.Энхгэрэл, Монгол улсын консерваторийн Бүжгийн тэнхмийн багш, дэглээч, МУСТА А.Хосбаяр, ЦДБЭЧ-ын концертмейстр, МУСТА О.Дарьхүү, хөгжим ангиас БХИС-ийн Хөгжмийн сургуулийн багш, МУСТА Ч.Наранхүү, Монгол улсын консерваторийн онолын багш Ч.Энхбат, чуулгын хөгжимчин Д.Мягмардорж, чуулгын Төлөвлөлт, зохион байгуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч С.Дуламсүрэн нар шалгалтыг авсан.

Шалгалтад дуу ангиас хамрагдвал зохих 10 дуучнаас хамрагдсан 10, бүжиг ангиас хамрагдвал зохих 10 бүжигчнээс хамрагдсан 9, хүндэтгэн үзэх шалтгаангүй тасалсан 1 /бүжигчин, цагдаагийн дэд ахлагч Б.Гантогтох/, өвчтэй 1 /бүжигчин, цагдаагийн ахлах ахлагч Э.Ундраа/, хөгжим ангиас хамрагдвал зохих 12 хөгжимчнөөс хамрагдсан 12 уран бүтээлчид оролцсон бөгөөд удирдамжид заасны дагуу шалгалтын материал боловсруулж, 100 оноогоор үнэлж А-6, В-9, С-7, D-1, F-3 дүгнэгдсэн.

Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/91 дүгээр тушаалаар батлагдсан “Хууль зүй дотоод хэргийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Монгол улсын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах үүднээс Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын орон тооны бус хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан алба хаагч нарыг чадавхжуулах сургалтад Хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн дэд ахлагч Г.Алтан-Эрдэнэ 09 дүгээр сарын 26-наас 28-ны өдрүүдэд хамрагдав.

Соён гэгээрүүлэх болон соёл урлагийн чиглэлээр: Чуулгын 45 алба хаагч 07 дугаар сарын 10-ны өдрийн 18.30-19.30 цагт Хүй долоон худагт үүрэг гүйцэтгэсэн цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын алба хаагчдад, 07 дугаар сарын 11-ний өдрийн 15.00-16.30 цагт хурдан морины уралдааныг үзэж сонирхохоор ирсэн иргэдэд урлагийн бүрэн хэмжээний тоглолтыг зохион байгуулж алба хаагчдын алжаалыг тайлж, иргэд олон нийтэд цагдаагийн байгууллагыг сурталчиллаа.

Чуулгын 10 бүжигчин 07 дугаар сарын 02-ны өдрөөс бэлтгэл сургуулилт хийж, 07 дугаар сарын 11-ний өдөр “Үндэсний их баяр наадмын нээлтийн ажиллагаа”-нд оролцож, уран сайхны удирдагч, цагдаагийн хошууч Г.Ариунбаатар 07 дугаар сарын 12-ны өдрийн 21.00 цагт Их жанжин Сүхбаатарын талбайд “Монгол сонгодог” уран бүтээлийн тоглолтоо өргөн барилаа.

ЦЕГ-ын даргаар 2018 оны 07 дугаар сарын 16-ны өдөр батлуулсан төлөвлөгөөний дагуу тус чуулгын бие бүрэлдэхүүн 2018 оны 07 дугаар сарын 17-ны өдрөөс 07 дугаар сарын 25-ныг хүртэлх хугацаанд Булган, Хэнтий, Архангай аймагт ажиллав.

07 дугаар сарын 17-ны өдөр Булган аймаг дахь цагдаагийн газрын 80 жилийн ойд зориулсан “Хүндэтгэлийн тоглолт”-д чуулгын бүжигчид бүрэлдэхүүнээрээ оролцож, 07 дугаар сарын 19-ний өдөр Хэнтий аймаг дахь цагдаагийн газрын 80 жилийн ойн “Хүндэтгэлийн тоглолт”-д дуучин, цагдаагийн ахлах ахлагч Э.Нямхүү уран бүтээлээрээ үйлчлэв.

07 дугаар сарын 20-ны өдөр Цэцэрлэг хотын төв Дэмид жанжины талбайд үлээвэр найрал хөгжим, дуучин, цагдаагийн дэслэгч Ц.Амарболд нар баярын жагсаалын урьдчилсан бэлтгэлийг хийж, 19.00 цагаас Архангай аймгийн Ихтамир сумын иргэд, хөдөлмөрчдөд “Үргэлж тантай хамтдаа” урлагийн бүрэн хэмжээний тоглолтыг өргөн барив.

07 дугаар сарын 21-ний өдөр Архангай аймгийн Хөгжимт драмын театрт зохион байгуулагдсан Цагдаагийн газрын түүхт ойг тэмдэглэн өнгөрүүлэх баяр ёслолын арга хэмжээний хүрээнд тус газрын үйл ажиллагаа, түүхэн замналыг иргэд, олон нийтэд сурталчлах зорилгоор “Арын хангайн цагдаа” баримтат киног хүндэт зочид, төлөөлөгчдөд толилуулах нээлтийн үйл ажиллагаанд үлээвэр найрал хөгжим, дуучин, цагдаагийн дэслэгч Ц.Амарболд хөтөлгөөр оролцож үйлчилгээ үзүүлсэн юм.

Түүнчлэн аймгийн төв талбайд зохион байгуулсан энэхүү баярын жагсаал, үзүүлэх тоглолт, ёслолын үйл ажиллагааг хөтлөхийн зэрэгцээ үлээвэр найрал хөгжимчид баярын жагсаалын хөгжмийг үлээсэн нь сүрлэг сайхан болсон төдийгүй уг арга хэмжээнд биечлэн оролцсон УИХ С.Мөнхбат, Ё.Баатарбилэг, Г.Тэмүүлэн, аймгийн засаг дарга Ц.Мөнхнасан болон оролцсон алба хаагч, иргэд сэтгэл ханамжтай байв.

Тус чуулгад томилогдсон 11 алба хаагчид цагдаагийн “А” үнэмлэх, энгэрийн тэмдэгийг баярын жагсаалын үеэр МУ-ын гавьяат хуульчид, генералууд, цагдаагийн байгууллагад нэр төртэй, алдар гавьяатай ажиллаж байсан үе үеийн ахмадуудаас ёслол төгөлдөр гардан авсан нь баяр наадмыг чимсэн төдийгүй Монгол цагдаа 3 цагийн хүндэтгэлтэй үргэлжлүүлж явааг харуулж, шинэ залуу алба хаагчдын хувьд гүн сэтгэгдэл төрүүлсэн юм.

Түүнчлэн Нутгийн захиргааны ордны их танхимд Архангай аймаг дахь цагдаагийн газрын түүхт 80 жилийн ойн баярын хурлын дараагаар “Хүндэтгэлийн концерт”-ийг тус чуулга зохион байгуулан урлагийн бүрэн хэмжээний тоглолтыг толилуулж, “Хүндэтгэлийн зоог” болон “Хаалтын арга хэмжээ”-ний үеэр урлагийн хэсэгчилсэн тоглолтоор үйлчиллээ.

07 дугаар сарын 22-ны өдөр тус чуулгын уран бүтээлчид Архангай аймаг дахь НАХ хэлтсийн даргаар 1973-1979 онд ажиллаж байсан хурандаа О.Дагвадорж, 1981-1990 онд ажиллаж байсан МУ-ын Гавьяат хуульч, цагдаагийн хурандаа Ш.Энхбат, 1990-1996 онд ажиллаж байсан цагдаагийн хурандаа Б.Ядамцоо, 1996-2000 онд ажиллаж байсан цагдаагийн хурандаа С.Отгонбаатар, 2000-2004 онд ажиллаж байсан цагдаагийн хурандаа Д.Сундуйсүрэн, 2004-2010 онд ажиллаж байсан цагдаагийн хурандаа Ц.Намсрайжав, цагдаагийн газрын даргаар 2014-2015 онд ажиллаж байсан цагдаагийн хурандаа Р.Болдбаатар, 2015-2016 онд ажиллаж байсан цагдаагийн дэд хурандаа Я.Ганбат, 2017 оноос хойш ажиллаж байгаа цагдаагийн хурандаа Э.Золбаатар нар болон тэдний гэр бүлийнхэнд хүндэтгэл үзүүлэхээр зочидын байрлаж буй “Хажуу модны амралт”-д очиж 1960-1980-аад оны хит дуу, бүжгийн тусгай хөтөлбөрөөр хүндэтгэлийн тоглолт хийв.

07 дугаар сарын 24-ний өдөр цагдаагийн байгууллагын ахмад удирдах ажилтан, цагдаагийн хурандаа С.Отгонбаатарын “Ургийн баяр”-т чуулгын тоглолтоор үйлчилж, баяр хүргэсний дээр Архангай аймаг дахь цагдаагийн газрын бие бүрэлдэхүүний 80 жилийн ойн үдэшлэгт уран бүтээлээрээ үйлчилж, газрын дарга Э.Золбаатарт цагдаагийн хурандаа цолоор шагнагдсанд баяр хүргэж амжилт ерөөлийг дэвшүүлсэн юм.

Архангай аймаг дахь цагдаагийн газрын хамт олны зүгээс ойн арга хэмжээнд гүн туслалцаа үзүүлж, соёл урлагаар үйлчилсэнд чин сэтгэлийн талархал илэрхийлэхийн зэрэгцээ цагдаагийн газрын “Баярын бичиг”-ээр хөгжимчин, цагдаагийн ахлах ахлагч Ю.Мэндчимэд, бүжигчин, цагдаагийн ахлах ахлагч Э.Ундраа, дуучин, цагдаагийн дэд ахлагч Г.Хатанбаатар, 80 жилийн ойн дурсгалын зүйлээр хөгжмийн багш, удирдаач, цагдаагийн ахмад Э.Батбаяр, олон нийттэй харилцах мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Б.Нямцэцэг, бүжгийн багш, бүжиг дэглээч, цагдаагийн дэслэгч У.Оюунномин нарыг шагналаа.

Орон нутагт томилолтоор ажиллах үеэр чуулгын алба хаагчдын дунд соён гэгээрүүлэх, биеийн тамир спортын цогцолбор “Буухиа” болон “Гар бөмбөг”-ийн тэмцээнийг зохион байгуулав.

Орон нутагт ажиллах явцад алба хаагчийн бэлэн байдал, аюулгүй байдал, сахилга, ёс зүйг хангаж, дэг журамтай ажиллах, учирч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх талаар 9 чиглэлээр баталгаа гаргуулж, алба хаагч нэг бүрээр гарын үсэг зуруулан, чуулгын даргаас үүрэг, чиглэл өгч биечлэн хяналт тавьж ажилласан болно.

Тус чуулгаас 2018 оны гуравдугаар улиралд “Үргэлж тантай хамтдаа” соён гэгээрүүлэх өдөрлөгийг Төв аймаг дахь цагдаагийн газар, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн гуравдугаар хэлтэс нийт 2 байгууллагад зохион байгууллаа.

Өдөрлөгийн хүрээнд 867 хүнийг хамруулж, 5 ахмад ажилтан, 3 алба хаагч, тэдний 23 гэр бүлийг алдаршуулж, 2 аж ахуй, нэгж, 1 иргэний хамтын ажиллагааг сурталчлан, талархал илэрхийлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль сурталчлах чиглэлээр 237 алба хаагч, 225 сурагч, давхардсан тоогоор нийт 1329 хүнийг хамруулан зохион байгуулсан.

Энэхүү арга хэмжээний хүрээнд 12 удаагийн бүрэн болон хэсэгчилсэн тоглолтоор үйлчилж, 2 удаагийн нэвтрүүлэг бэлтгэн, 3 телевиз, 3 цахим хуудас, 6 хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажилласан.

Чуулгаас зохион байгуулсан “Үргэлж тантай хамтдаа” соён гэгээрүүлэх өдөрлөгийн нэвтрүүлгийг бэлтгэн чуулгын албан ёсны www.suld.police.gov.mn цахим хуудас, ЦЕГ-ын Сүлд чуулга /Suld ensemble of Mongolian police/ фейсбүүк хуудас, www.youtube.com хуудсанд байршуулан олон нийтэд хүргэж байна.

Цагдаагийн байгууллагын 2018 оны “Хөлбөмбөгийн аварга” шалгаруулах тэмцээнд тус чуулгаас 12 хүний бүрэлдэхүүнтэй баг амжилттай оролцов.

Уран бүтээлийн чиглэлээр: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудаас ирүүлсэн 13 албан бичиг, хүсэлтийн хүрээнд 13 удаагийн тоглолтын хөтөлбөр боловсруулж, соёл урлагаар үйлчлэв.

Тухайлбал, Япон улсын Цагдаагийн ерөнхий газрын Олон улсын хамтын ажиллагааны асуудал эрхэлсэн гүйцэтгэх захирал, хурандаа Нобору Накатани тэргүүтэй төлөөлөгчдийн Монгол улсын Цагдаагийн ерөнхий газарт хийх айлчлал, Бүгд найрамдах Солонгос улсаас Монгол улсад суугаа элчин сайдын яамнаас 2018 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр Сөүлийн гудамжинд зохион байгуулсан Солонгосын соёлын өдөрлөг-2018”, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Засаг захиргааны дэд тэргүүлэгч бөгөөд нийгмийг аюулаас хамгаалах тэнхмийн дарга Ян Вэйдөн тжргүүтэй төлөөлөгчид Монгол улсын Цагдаагийн байгууллагад хийх айлчлал,

Тус чуулгын үлээвэр найрал хөгжмийн бүрэлдэхүүн энэ оны 3 дугаар улиралд 20, дуучид 70, бүжигчид 15 удаагийн нийт 105 арга хэмжээнд уран бүтээлээр үйлчилж, хөгжмийн 3, дууны 7, бүжгийн 8, нийт 18 уран бүтээлийг шинээр гаргасан байна.

МУ-ын Төрийн соёрхолт, УГЗ, Тэргүүн зэргийн “Чингис хааны одон”-т хөгжмийн зохиолч Б.Шаравын нэрэмжит “Сэрсэн тал” мэргэжлийн дуу дуулаачдын улсын уралдаанд дуучин, цагдаагийн дэслэгч Ц.Амарболд, цагдаагийн дэд ахлагч Д.Содномдаржаа, Г.Ганшагай нар оролцож, дуучин цагдаагийн дэд ахлагч Г.Ганшагай III байр эзэлсэн амжилт гаргалаа.

Түүнчлэн дуучин цагдаагийн дэд ахлагч М.Бямба-Эрдэнэ “Авьяаслаг Монголчууд” шоуны шилдэг 32 оролцогчийн нэгээр шалгарч, дуучин, цагдаагийн дэслэгч Ц.Амарболд БНХАУ-ын Нингбо хотод зохиогдох олон улсын дуурийн

дуулаачдын “А” зэрэглэлийн уралдаанд оролцохоор бэлтгэл сургуулилтыг хийж байна.

Гурав. Санхүү, бүртгэл, санхүү хангамж, үйлчилгээ, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах талаар

ХБНГУ-н “Buffet Crampon” хөгжмийн үйлдвэрийн албан ёсны хөгжмийн дэлгүүр ELCODA холбогдож үнийн санал, гэрээг орчуулан танилцуулж талууд гарын үсэг зурж БСШУС-н яаманд хүргүүлсэн.

“Бөртэтрейд” ХХК-аар дараах ажлуудыг хийж гүйцэтгүүлсэн байна. Үүнд

1.Сантехникийн иж бүрэн засвар: Шугамын засвар, шинэчлэлийн ажлыг төсөвт тусгагдсанаар гүйцэтгэж, 1-3 давхарын радиоторуудыг нэг бүрчлэн угааж шугамыг даралттай хүйтэн усаар дүүргэлт хийсэн.

2.Гадна фасадын засвар: Чуулгын байр баруун жигүүрийн 4 цонх тоосгоор битүүлж өрөөд хоёр талыг битүүлж, унасан халцарсан шавруудыг нөхөж объектын 4 талыг өнгө дагуу цавуун будгаар будаж гадна пасадны өнгийг сэргээн засварласан.

3.Төв хаалгыг солих: 43,10^{М²} шилэн хаалгаар сольсон

4.Музейн болон бүжгийн хувцасны өрөөний 7 ширхэг цонхыг вакуум цонхоор сольсон.

5.Объектын баруун, зүүн, хойд талуудын гадна ханын давхар байрлалтай 6 ширхэг хаалгыг хамгаалалтын төмөр болгон шинэчилж сольсон

6.Рекламны 8 ширхэг гэрэлт самбар хийж бэлэн болгосон.

7.Хөгжим ангийн ханыг бүтэн эсгий хавтангаар бүрсэн, шалыг паркетан шал болгосон.

8.Бүжгийн заалны хананы өнгийн сэргээж, шалыг паркетан шалаар шаллаж, бүжгийн бэлтгэлийн хулдаас авч өгсөн.

9.Дотоод болон гадаад аюулгүй байдлыг дээшлүүлэх үүднээс 25 ширхэг сүлжээний камер суурьлуулж дотоод сүлжээнд холбосон.

Тайлант хугацаанд давхардсан тоогоор 140 уран бүтээлчид 6 аймагт нийт 0,68 сая төгрөгийн томилолтын зардал үүсгэн ажилласан нь Монгол улсын сангийн сайдын 2011 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 132 тоот “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тушаалаар тогтоосны дагуу албан томилолтын зам хоног, байрны зардын хэмжээ 15,4 сая төгрөг байхаар тооцсоноос нийт 14,7 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Баянзүрх дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Хангалт үйлчилгээний төвийн урд талд “Цагдаа-Амгалан” хотхоны 2 дахь ээлжийн захиалгад нийт 13 алба хаагч орон сууцанд хамрагдах санал өгсөнөөс одоогийн байдлаар захиалгын гэрээг 4 алба хаагч байгуулсан байна.

Дөрөв. Дотоод хяналтын хүрээнд

Цагдаагийн алба хаагчдын аюулгүй байдлын өнөөгийн түвшин, цаашид авч хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох зорилго бүхий санал асуулгыг чуулгын 32 алба хаагчаас авч нэгтгэн 2018 оны 26/190, Засгийн газрын 2017 оны 01 тоот албан даалгаварын биелэлтийг 26/188 дугаартай албан бичгээр ЦЕГ-ын Аюулгүй байдлын хэлтэт тус тус хүргүүлэв.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/178 дугаар тушаалын дагуу Тулгар төрийн 2227, Их Монгол улсын 812, Ардын Хувьсгалын 97 жилийн ой, Үндэсний их баяр амралтын өдрүүдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор чуулгын даргын А/129 дүгээр тушаалаар тус чуулгын бие бүрэлдэхүүнийг 2018 оны 07 дугаар сарын 09-ний 19.00 цагаас 07 дугаар сарын 15-

ны өдрийн 20.00 цаг хүртэлх хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын хоёрдугаар зэрэглэлд шилжүүлэн ажиллалаа.

ЦЕГ-ын дарга болон чуулгын даргын өгсөн үүрэг чиглэлийг бүрэлдэхүүнд нэгбүрчлэн танилцуулахын зэрэгцээ чуулгын даргын тушаалын хавсралтаар баталсан хуваарийн дагуу жижүүрийн 3 цагдаа, 7 офицер нийт 10 алба хаагч давхардсан тоогоор 14 удаа чуулгын байранд хяналт тавин, удирдлагаас өгсөн үүргийг хэрэгжүүлж, чуулгын удирдлагыг мэдээллээр ханган зөрчил дутагдалгүй ажиллаж, чуулгын дарга 2 удаа нөхцөл байдалтай биечлэн танилцаж, үүрэг чиглэл өгөв.

----- СҮЛД ЧУУЛГА -----